БАТЛАВ. ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА ..... Б.АМАРТҮВШИН

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН РАШААНТ, НАРАН БАГИЙН ИРГЭДИЙН ХАЛУУН УСНЫ БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2026 оны 02 сарын 23 –ны өдөр. Дугаар : ХОАЖСЗДТГ/20260203006 Ховд хот.

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	*Жаргалант сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 11–ны өдрийн ээлжит VI дугаар хуралдааны Э/06/04 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтанд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 2.6 дахь заалтад тусгагдсан ХОАЖСЗДТГ/20260203006 дугаар бүхий ажил*
2.	Ажлын нэр /төрөл/, Байршил	Ховд аймгийн Жаргалант сумын рашаант, наран багийн иргэдийн халуун усны барилгын зураг төсөв боловсруулах ажил, ХОАЖСЗДТГ/20260203006 Хаяг: 9-р баг, Рашаант баг, Сангийн - 10 гудамж, 1001 тоот, Шуудангийн бүсчлэл – 84147, Хуучин Шим-Усны халуун ус
3.	Захиалагч байгууллага	Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Ховд хотын Захирагчийн ажлын алба
4.	Төсөвт өртөг	40 сая төгрөг
5.	Санхүүжилтийн эх үүсвэр	Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалт
6.	Төсөл хэрэгжих газрын хэмжээ /зориулалт, хүчин чадал/	1122 $м^2$ талбайд төлөвлөнө /Хуучин Шим-Усны халуун усны байршилд / Наран, Рашаант багийн халуун усны 12м х 12м харьцаатай /144 $м^2$/ 2 давхар барилгын зураг төсөв боловсруулах ажил /Ховд, Жаргалант сум, Рашаант баг/ Олон нийтийн үйлчилгээний барилгын иж бүрэн зураг , төсөв, Инженер геологийн судалгааны хамт
7.	Гүйцэтгэгч, Зураг төсөл боловсруулах байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" Монгол улсын хуулийн дагуу зөвлөх үйлчилгээгээр сонгон шалгаруулна. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /ТШӨХ/-д заагдсан тусгай зөвшөөрөлтэй, хуулийн дагуу тендерт шалгарч, гэрээ байгуулсан, тухайн чиглэлийн зураг, төсөл боловсруулж байсан ажлын туршлагатай аж ахуйн нэгж байна. <u>Дор дурдсан тусгай зөвшөөрөлтэй байна :</u> • ЗТ-4.1 Барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл, орчны тохижилт болон түүнээс дээш; • ЗТ-6.1 Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл болон түүнээс дээш; • ЗТ-6.2 Барилга байгууламжийн дотор халаалт, салхивч, хөргөлтийн систем, гадна дулааны салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл болон түүнээс дээш; • ЗТ-6.3 Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, 35кВ хүртэлх гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөремжийн хянах, хэмжих хэрэгсэл автоматикийн зураг төсөл болон түүнээс дээш; • ЗТ-6.4 Барилга байгууламжийн дотор мэдээлэл холбоо, галын болон бусад дохиоллын системийн зураг төсөл, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл болон түүнээс дээш; • ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв (тухайн ажлын төрлийн хүрээнд) болон түүнээс дээш;

8.	Хэрэгжих хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд хугацааг тодорхой заана. /гэрээ байгуулсанаас хойш 45 хоногт багтаан гүйцэтгэнэ/
9.	Зураг төсөл боловсруулах үе шат	2026 оны 3-р улиралд багтаан дуусгах, гурван үе шаттай байна. **I-р үе шат:** • Бэлтгэл ажил /инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга/; • Бодит байдлын талаарх судалгаа хийх /гадна шугамын одоогийн нөхцөл байдал, хэрэглэгчдийн судалгаа гэх мэт/ **II-р үе шат:** Эскиз батлах, зөвшөөрөлцөх /Захиалагчтай/ • Захиалагч талын төлөөлөлтэй зөвшилцөх **III-р үе шат:** Ажлын зураг төсөв магадлалаар баталгаажуулан хүлээлгэн өгөх. • Хангагч талын гаргаж өгсөн техникийн нөхцөлүүд, холбогдох БНбД-д заасны дагуу ажлын зураг, төслийг боловсруулах. • Ажлын зурагт магадлал буюу экспертиз хийлгэх. • Зураг төслийн дагуу барилга, угсралтын ажилд шаардагдах зардлын хяналтын төсвийг гаргах. • Баталгаажуулсан зураг, төслийг хүлээлгэн өгөх,
10.	Зураг төслийн иж бүрдэл, тавигдах шаардлага	Баримт бичгийн иж бүрдэл : ✓ Инженер геологийн дүгнэлт ✓ Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах ✓ Онцгой байдлын дүгнэлт ✓ Магадлалын ерөнхий дүгнэлт /хавсралт дүгнэлтүүдийн хамт/ Зураг, төслийн иж бүрдэл : ✓ Эскиз зураг /батлагдсан/ ✓ Ажлын зураг /батлагдсан/ ✓ Үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөө - ЕТ ; ✓ Барилга архитектур - БА ; ✓ Технологийн зураг -ТЗ ; ✓ Барилга бүтээц /Бүтээцийн тооцооны хамт/ - ББ ; ✓ Халаалт, агаар сэлгэлт - ХАС ; ✓ Цэвэр, бохир ус - ЦБУ; ✓ Хүчит төхөөрөмж – ХТ ; ✓ Гадна, дотор, гэрэлтүүлэг - ГДГ ; ✓ Холбоо дохиолол – ХД ✓ Дулаан хангамж - ДХ ; ✓ Цахилгаан хангамж – ЦХ ; ✓ Ус хангамж ариутгах татуурга – УХАТ ; ✓ Автоматик, удирдлагын зураг төсөл ; ✓ Тохижилт, автозогсоолын ажлын зураг төсөл – ТАЗ; ✓ Төсөв - магадлал хийсэн ажлын зураг төслийн дагуу төсвийг программаар гүйцэтгэх; ✓ Мэргэжпийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, зөвлөмж; ✓ Барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийсэн дүгнэлт; ✓ Барилгын зураг төсөлд галын аюулгүй байдлын хяналт хийсэн тухай дүгнэлт; ✓ Ажлын зургийн магадлалын дүгнэлт. Ажлын зураг төслийг норм дүрэм, стандартын дагуу төлөвлөх ба бүх ажлын зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөж, батлуулан, магадлал хийгдсэн байх; <u>Ажил гүйцэтгэх аргачлал:</u> ❖ Барилга байгууламжийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, орчны тойм, эзлэхүүн төлөвлөлт, барилгын нүүр тал /фасад/, өнгөний шийдэл, төлөвлөлтийг тодорхойлсон загвар зургийг боловсруулж барилгын асуудал хариуцсан байгууллагаар хянуулах, Захиалагчтай зөвшилцөх; ❖ Загвар зураг болон магадлал хийлгэсэн ажлын иж бүрэн зураг, төсвийг холбогдох баримт бичгүүдийн хамт эх хувь 2 хувь, хуулбар 2 хувь, файл /autoCad, PDF, төсөв зохиосон программын өргөтгөлтэй/ хэлбэрээр CD-д бичиж 1 хувь хүлээлгэн өгнө. Төсөвт барилгын материалын үнийг стандартын шаардлага хангасан материалаар тооцож тусгах шаардлагатай.

11.	Төсөл гүйцэтгэхэд ашиглах норм, дүрэм, стандарт	***Монгол Улсын хуулиуд:*** - Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай Монгол Улсын хууль - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Газрын тухай хууль - Эрчим хүчний тухай хууль - Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 - Усны тухай хууль, - Эрүүл ахуйн тухай хууль, 2017 - Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль; - Бусад хууль тогтоомж ***Монгол Улсын стандарт, норм норматив***ууд: - MNS 3757-3:2013 Барилгын зураг. Техникийн төсөл ба ажлын зурагт тавих ерөнхий шаардлага. - MNS 5163:2002 Халуун усны үйлчилгээ, ерөнхий шаардлага - MNS 5164:2010 Сауны үйлчилгээ, ерөнхий шаардлага - MNS 3238:2001 Дулаан шугам сүлжээ. Ажпын зураг. Дулаан механикийн хэсэг. - MNS 3240:2013 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционерын системийн ажпын зураг - MNS 4244:1994, Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага - MNS 6055:2009, Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага; - MNS 4585:2016, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага; - MNS 4582 Барилгын дотор талын засал, чимэглэл будаг - MNS 5802:2007 Барилгын цонх Техникийн ерөнхий шаардлага; - UCS 1504C:2023 Хаалга, цонхонд тавигдах ерөнхий шаардлага; - UCS 2001C:2023 Дуу чимээ, дулаан тусгаарлах материалд тавигдах ерөнхий шаардлага; - MNS 3672:84 Хөрс. Барилга байгууламжийн хээрийн хэв гажилтыг хэмжих аргууд - MNS 3263:2014 Хөрсний ангилал - MNS 0392-1998 Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс - MNS 0346-2000 Барилгын ажилд хэрэглэх хайрга, буталсан хайрга - БНбД 81-95-12/2020/ Барилгын төсөв зохиох дүрэм - БНбД 81-16-20 Зураг төслийн ажлын жишиг үнэ - Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохицуулах журам - БНбД14-01-07 Хот байгуулалтын кадастер - БНбД 50-01-16 Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм - БНбД 11-02-02 Зураг төсөлд экспертиз хийх дүрэм - БНбД 11-01-98 Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм - БНбД 11-06-03 Зургийн ерөнхий инженер/ерөнхий архитектор/-ын дүрэм - БНбД 11-105-06 Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил - БНбД 30-02-08 Ган бүтээц /зураг төсөл боловсруулах норм ба дүрэм/ - БНбД 11-03-01 Барилгын инженер-геологийн ажил гүйцэтгэх дүрэм - БНбД 11-08-23 Барилга байгууламжийн геодезийн ажил - БД 11-03-21 Барилгын инженер-геологи , геотехникийн судалгааны ажил - БНбД 22.01.21*/2022 Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм - Цэвдэгтэй бүс нутагт барилга, байгууламж төлөвлөх норм ба дүрэм - БНбД 30.01.04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм - Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн дүрэм /ЗГ-ын 2020 оны 97-р тогтоолын 1-р хавсралт/ - Дулааны эрчим хүч хэрэглэгчийн дүрэм /ЗГ-ын 2020 оны 97-р тогтоолын 2-р хавсралт/ - ЭХД-2-21-01-2003. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм - ЭХД-1-13-02-2006. Хэрэглэгчийн цахилгаан, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм

		- ЭХД-2-20-01-2013. Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм - ЭХД-1-12-04-2013. Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм - ЭХД-1-12-02-2007. Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм - ЭХД-1-12-03-2010.Уурын ба усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм - ЭХД-1-12-05-2013.Уур, халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм - БД 43-101-03 Цахилгаан байгууламжийн дүрэм; - БНбД 3.05.06-90 Цахилгаан техникийн ажил - БНбД 13.04.03 Барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм, - БД12.101.05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар - БНбД 31-03-03 Олон нийт иргэний барилга - БНбД 43-102-07. Орон сууц олон нийтийн барилгын цахилгаан төхөөрөмжийг төлөвлөх ба угсрах - БНбД 43-103-08. Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар - БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм - БНбД 31-23-22 Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх; - БНбД 40-05-16 Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга - БНбД 23-02-08 Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг. - БНбД 41-01-11 Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер; - БНбД 41-01-02 - Агаар сэлгэлт ба кондиционерийн системийн ерөнхий барилгын норм ба дүрэм; - БНбД 40-02- 06 Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж - ЗЗБНбД 22-004-2016 Авто зам төлөвлөх - БНбД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал - БНбД 21-02-02 Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм - БНбД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл - БНбД 40 -06-16 Дотор сантехникийн систем - БНбД 41-02-13 Дулааны сүлжээ - БНбД 41-05-18 Дулааны сүлжээ - БНбД 03 -05-07.90 Автоматжуулалтын систем - БНбД 41 -03-07 Зуухны тоног төхөөрөмж - БНбД 81-16-06 Дотор цэвэр усны ажил - БНбД 81-17-06 Дотор бохир усны ажил - БНбД 81-18-06 Дотор халаалтын ажил - БНбД 81-19-06 Салхижуулалтын, агаар сэлгэлтийн ажил - БНбД 81-21-06 Гадна цэвэр усны ажил - БНбД 81-22-06 Гадна бохир усны ажил - БНбД 81-23-06 Гадна дулаан хангамжийн ажил - БНбД 81-24-06 Дулаан тусгаарлалтын ажил - БНбД 81-34-06 Үйлдвэрийн зуух яндангийн ажил - БНбД 81-20-04 Орон сууц, олон нийтийн барилгын гэрэлтүүлэг - БНбД 81-30-04 Цахилгаан дамжуулах шугамын ажил - БНбД 81-40-04 Барилгын холбоожуулалтын ажил - БНбД 81-60-05 Тогоо, ус халаагч, дулааны зангилааны ажил - БНбД 81-61-05 Цэвэр ус, дулааны шугам хоолойн ажил - БНбД 81-62-05 Халаах хэрэгслэлийн ажил - БНбД 81-63-05 Салхивчийн ажил - БНбД 81-64-05 Бохир усны шугам хоолойн ажил - БНбД 81-70-05 Цахилгааны ажил - Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад холбогдох норм, нормативын баримт бичгийг баримтлана.

12.	Төслийн талбай	• Ховд аймгийн Жаргалант сум, Рашаант баг, Сангийн - 10 гудамж, 1001 тоот хаяг /"Хуучин Шим-Усны халуун ус"-ны байршил/-т байрших 1122 $м^2$ газар, Шуудангийн бүсчлэл – 84147
	Барилгажих талбай	• Эдэлбэр газрын 60%-аас ихгүй талбай 673.2 $м^2$ (ХБТХууль 12.8) Үүнээс : Халуун усны барилгын эзлэх талбай 196$м^2$ Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНбД 30-01-04/-ийн дагуу төлөвлөх.
	Ногоон байгууламж, гадна тохижилт төлөвлөх талбай	• Эдэлбэр газрын 20%-аас доошгүй талбай (ХБТХууль 12.6.3)
	Авто зогсоол	БНбД 30-01-03 болон (ХБТХууль 12.6.3)- г баримтлан төлөвлөх • Унадаг дугуйн зам, зогсоол төлөвлөнө. • Зорчигч, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн авто зогсоолыг хүртээмжтэй байдлаар төлөвлөх; • Авто зогсоол болон явган зам талбайг ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт хийх, • Авто зогсоолын төлөвлөлтийг орчны байдал, төлөвлөлттэй уялдуулан тев авто замтай холбох, орц гарцыг нэгтгэн төлөвлөнө.
13.	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага	*Одоо байгаа хуучин халуун усны барилгыг нураан буулгаж, халуун усны* барилгыг норм, стандартын дагуу шинээр барихаар төлөвлөх. Үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газар, тохижилтод тавигдах шаардлага : • Ховд хотын ногоон бүс, орчны тохижилт, автозамтай уялдуулж, инженерийн байгууламж, шугам сүлжээний ажлын зураг төслийг эх үүсвэр болон хэрэглэгчтэй холбох хүртэл иж бүрнээр боловсруулах • "Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" /БНбД 30-01-04/ -г баримтлах; • Гудамж зам талбайн тохижилт, явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүйгээр онцгой нөхцөлд галын машин чөлөөтэй зорчих орц, гарц төлөвлөнө. • Эдэлбэр газрын талбайд холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу ногоон байгууламж төлөвлөх, 1,5м-ээс багагүй өндөртэй ногоон байгууламж эсвэл хашаагаар хүрээлэгдсэн байх; • Авто машины зогсоолыг холбогдох стандартын дагуу төлөвлөх; • Эдэлбэр газрын талбайн гэрэлтүүлгийг холбогдох норм, дүрмийн дагуу төлөвлөх; • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлага, өндөр настан, бага насны хүүхдийн биеэ авч явах нөхцөл байдалд нийцүүлэн холбогдох норм, дүрмийн шаардлагын дагуу төлөвлөх; • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан авто зогсоол төлөвлөх; • Явган хүний зам нь хатуу, нягт, халтирахаас сэргийлсэн гадаргуугаар хийгдсэн байх бөгөөд хөтөч хавтан төлөвлөх; • *Барилгын гол орц, гарц хэсэгт тусгай хэрэгцээт иргэнд зориулсан алгуур* налуу бүхий налуу замыг БНбД-ийн дагуу 1:12 төлөвлөх/;
14.	Барилга байгууламжийн ерөнхий байдал, бүрэлдэхүүн хэсэг, төлөвлөлт	Загвар дизайны хувьд өвөрмөц, өнгө үзэмж, загварын орчин үеийн хэв маягыг агуулсан метал хийцлэлийн фасадтай байх /өнгө дизайны шийдлийг захиалагчтай зөвшилцөнө./ Халуун усны барилга нь зоорьгүй, 12м Х 12м хэмжээтэй, 2 давхар барилга Барилгад төлөвлөх өрөө: ✓ Гонх ✓ Хүлээлгийн танхим, Касс ✓ Эрхлэгчийн өрөө ✓ Душны өрөө ✓ Душны өрөө VIP ✓ Нойтон саун ✓ Үсчин ✓ Ариун цэврийн өрөө. эрэгтэй, эмэгтэй, тусгай хэрэгцээт /Суултуур, тосгуур/ ✓ Аж ахуйн өрөө /ажилчдын хувцас солих+материал хэрэгсэл

		хадгалах/ ✓ Узелийн өрөө /хэрэгцээний халуун ус бэлтгэхэд зориулсан төхөөрөмжийн зайтай байх/; ✓ Цахилгааны өрөө ✓ Хуурай хими цэвэрлэгээ+угаалга ✓ Угаалгын өрөө ✓ Тусдаа хаалга бүхий галлагааны өрөөтэй байхаар төлөвлөх. **<u>Төлөвлөлтийн шаардлага:</u>** • Үйлчлүүлэх иргэдэд зориулж үүдний хэсгийг зайтай төлөвлөх; • Шал болон шат нь хөдөлгөөнд саад учруулахгүй нэгэн жигд түвшинтэй, орчин үеийн технологийг тусгасан зориулалтын материалаар төлөвлөж тайлбар бичигт тусгах; • Давхрын талбай нь үүрэг зориулалтын хувьд үр ашигтай архитектур орон зайн зөв зохион байгуулалттай байх; • Иргэдийн тав тухтай үйлчлүүлэх, чөлөөтэй зорчих, ээлжээ хүлээх орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх; • Өдрийн турш байгалийн гэрэл, агаар солилцоог бүрэн авч байх нөхцөлийг нарийн тооцоолох; • Нийтийн бие засах газрыг эрэлт хэрэгцээнд нийцүүлэн төлөвлөх; • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц гарц, пандусыг стандарт (MNS 6056:2009; 6055:2009) болон Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх БНбД 35-01-22-н дагуу төлөвлөнө. • Төлөвлөж буй барилга орчмын гудамж замын зэрэглэлд тавигдах шаардлага, стандарттай нийцүүлэн барилгын гадна фасадыг цаг уурын онцлог (эрс тэс уур амьсгалтай хот)-т тохируулж барилгын чанар стандартад нийцсэн ачаалал даахуйц материал ашиглах. • Загвар зурагт өнгөний код, материалыг тодорхой тусгах, барилгын гадна фасадад барилгын дулаалгын хөөс, бусад шаардлага хангахгүй материал ашиглахгүй.
15.	Барилгын үндсэн бүтээц, материал хийц	❖ ***Суурь:*** *Барилгын нженер геологийн дүгнэлтийг үндэслэн* БНбД-ийн дагуу суурь суулгалтын зургийг гүйцэтгэнэ.Цутгамал төмөр бетон баганан суурь /хучилт, дам нуруу бүхий хөндийлж хэсэг буюу цэвдэг хөрсөнд суурь төлөвлөх 1-р зарчмын дагуу/ цутгамал төмөрбетоны ажлыг БНбД 83-4^{Б}-01-г баримтлах. Барилгын буурь суурийн норм ба дүрэм (БНбД 50-01-16) – г баримтлах. ❖ ***Үндсэн хийц:*** • Цутгамал төмөр бетон арагт бүтээц; • Өрөгт бүтээц БНбД 51-02-05 хангасан байна. ❖ ***Хана:*** Өрөгт бүтээц БНбД 51-02-05, 100мм чулуун хөвөн дулаалга, 100мм метал хийцлэлийн фасадтай төлөвлөх Хамар хана: Тоосгон өрөг Өргийн ажлыг БНбД 51-02-05-н дагуу ❖ ***Дээвэр:*** Стандартын шаардлага хангасан, БНбД-31-02-03, БНбД-31-07-05 дагуу салхижуулалтгүй хавтгай дээвэр төлөвлөх, Дээврийн ажлыг БНбД 31-07-05, БД 31-108-08 норм дүрмүүдээс холбогдох заалтуудыг авч төлөвлөнө. ❖ ***Хаалга:*** ISO стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэгчийн зөвшөөрөлтэй хаалга төлөвлөх. Хаалгаар орох хэсэгт шилэн хөлийн өрөө /гонх/ төлөвлөж өгөх. Гадна хаалга дулаалгатай металл хаалга, дотор хаалгыг стандартын шаардлага хангасан зориулалтын сайн чанарын үйлдвэрийн модон хаалга, шинэ дэвшилтэт материал ашиглахаар төлөвлөх бөгөөд стандартын дагуу бүгд гадагш түлхэж онгойдог байхаар төлөвлөх. ❖ ***Цонх:*** Бүх цонхыг аргоноор дүүргэсэн, шил хоорондоо багадаа 12 мм зайтай, дулааны үр ашигтай, гурван давхар 1о\л/-Е шиллэгээ, хүйтэнд тэсвэртэй резин жийрэг, багадаа 5 камер бүхий 80 мм PVC хүрээтэй байхаар төлөвлөх; ❖ ***Шал:*** БНбД 31-09-05, БД31-109-08 дагуу гүйцэтгэхээр төлөвлөх. Өрөөнүүдийг зориулалтаас нь хамааруулж /плита, паркет, зориулалтын хулдаас/ зэргийг орчин үеийн сайн чанартай материал сонгож төлөвлөх.

		❖ ***Шат:*** Барилгын шат төмөр бетон цутгамал хийцтэй байх ба халтиргаа үүсгэдэггүй хиймэл чулуун хавтан ашиглах ба төмөр сарааж хашлага бариул хийнэ. Гишгүүрийн ирмэгт халтирахаас хамгаалсан хобил татах буюу зариулалтын металл ба резинэн оруулга суулгаж өгнө.Барилгын шат болон коридорт аль болох механик элэгдэл, ус чийгэнд тэсвэртэй өнгөлгөөний материал хэрэглэнэ. Гадна шат довжооны хэвтээ гадаргууг халтиргаа үүсгэдэггүй бор саарал өнгийн барзгар гадаргуутай хиймэл чулуугаар өнгөлнө. ❖ ***Гадна, дотор засал:*** Дулааны техникийн тооцоог үндэслэн барилгын нийт ханын дотор, гадаргууд сайн чанарын шавардлага хийж хөөсөнцөр дулаалгатай зориулалтын метал хийцлэлийн фасад ашиглан хийх ба ус зайлуулах цорго/хаялга хийж,Гадна хаяавчийг цутгана. Ханын гадаргуугийн нүх сүв, чигжээсүүдийг сайтар бөглөж, тэгшилж цэвэрлэнэ. Орчин үеийн барилгын стандарт норм дүрэмд нийцсэн материал сонгож төлөвлөх ба дотор будгийг эрүүл ахуйд нийцсэн эко будгаар будах, заслын ажил /БН6Д31-10- 05/- г баримтлах, Галд шатдаг материал барилгын үндсэн хийцэд ашиглахгүй байх, ❖ ***Гадна тохижилт:*** Гадна тохижилт, хашаа, хайс, явган зам талбайг орчны зам талбайтай уялдуулан төлөвлөх 'Хот тосгоны төлөвлөлт" БНбД 30-01-04, БНбД 3.01.06-90 стандарт норм дүрмээс холбогдох заалтыг авч төлөвлөх. Гадна гэрэлтүүлэг, зам талбай, тохижилтод орчин үеийн чанартай материал сонгож төлөвлөх,
16.	Инженерийн шугам сүлжээ, тавигдах шаардлага, Инженерийн шугам сүлжээг хангах эх үүсвэр	Эх загвар зурагт үндэслэн ачаалал тооцож хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлийн хүрээнд гадна инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулах, техникийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эх үүсвэртэй байхаар холбогдох норм, дүрэм, стандартын дагуу инженерийн шугам, сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах. Үүнд: ❖ Техникийн нөхцөлийн дагуу төвийн шугам сүлжээнд холбох; ❖ Дэвшилтэд технологи бүхий байгаль орчинд ээлтэй хувилбараар бие даасан байдлаар шийдвэрлэх. • Усны өөрийн эх үүсвэрийн худаг ашиглаж байгаа тохиолдолд худгийн эргэн тойрон 50м-т эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож хашаажуулах зай талбайг хангалттай төлөвлөх; • Ус нөөцлөх савыг зориулалтын, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн материалаар хийх, ус нөөцлөх савыг халаалтын зуухнаас тусдаа өрөө тасалгаанд таазанд тулгахгүйгээр угааж цэвэрлэх, халдваргүйжүүлэлт явуулах боломжтой, агаарын солилцоо хийгдэх боломжтой байхаар төлөвлөх; • Бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжтай бол зай талбайн хэмжээг тооцох, цэвэрлэсэн бохир усыг цооногт цуглуулж хөрсөнд хаяхгүй зөөвөрлөхөөр төлөвлөх; • Бохир ус цуглуулах цооногийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын А/82/128 хамтарсан тушаалаар батлагдсан "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам"- ын дагуу зураг төслийг хийсэн байх. • Зураг төсөлд холбогдох БНбД-үүд техникийн нөхцөл шаардлагын хүрээнд инженерийн шугам сүлжээнд нэвтэрч буй шинэ дэвшилтэт материалыг ашиглахаар тусгах. **<u>Ус хангамж, ариутгах татуурга :</u>** ✓ Усан хангамжийн бие даасан системтэй, ойролцоох худгаас технологийн дагуу татаж нийлүүлэх байдлаар төлөвлөх, ✓ Ариутгах татуургын шугам сүлжээг бие даасан иж бүрэн ариун цэврийн байгууламжтай байхаар төлөвлөх; ✓ Гадна галын гидрантыг нормын дагуу төлөвлөх; ✓ Усны шинж чанарын үзүүлэлтээс хамаарч ус боловсруулах төхөөрөмжүүдийг төлөвлөх; ✓ Усны хэмнэлттэй тоноглолуудыг сонгох; ✓ Цэвэр усны нөөцийн сав төлөвлөх;

		Дулаан хангамж : ✓ Бие даасан дулааны өөрийн эх үүсвэр хатуу түлшний зуух ашиглах, цахилгаан, сэргээгдэх эрчим хүч хосолсон байдлаар эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг сонгож халаахаар төлөвлөх /боломжит хувилбарыг сонгох/. ✓ Барилгын хүчин чадалд тохируулан МУ-н MNS 5045:2001 стандартад нийцсэн тоног төхөөрөмж ашиглах ба БНбД 41-01-11-т нийцүүлэн төлөвлөх ✓ Халаалтын цогц төхөөрөмжүүд, шугам хоолой тоноглолууд нь дулааны алдагдал багатай эрчим хүчний хэмнэлттэй байхаар зураг төсөлд тусгах; ✓ Хэрэгцээний халуун усыг бие даасан байдлаар шийдвэрлэхээр зураг төсөлд тусгах; **Цахилгаан хангамж :** ✓ Төвийн эрчим хүчний сүлжээнээс техникийн нөхцөлийн дагуу холбох болон аваарын үед ашиглах бие даасан эх үүсвэртэй байх; ✓ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг /нар, салхи/ хуримтлуурын хамт тооцож ашиглах /боломжтой бол/; ✓ Цахилгаан системийн автоматжуулалттай уялдуулсан байх; ✓ Цахилгааны утас болон тоноглол хэсгүүд нь ISO стандартын шаардлага хангасан байх ба цахилгааны утсыг зориулалтын сувагчлалаар аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэхээр төлөвлөх, **Халаалт, агаар сэлгэлт :** ✓ Тооцооны үндсэн дээр оновчтой төлөвлөсөн агааржуулалтын системтэй төлөвлөж өгөх. "Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер" БНбД 41-01-11 –ийг баримтлах. ✓ Халаалтын систем нь блокууд, шатны хонгил, техникийн, зоорийн давхрын хэсгүүд тус тусдаа бие даасан халаалтын системтэй байх; ✓ Халаах хэрэгслийн төрөл нь ган конвекторон радиатор байх; ✓ Босоо шугам бүрд таслах хаалт зарцуулалт, даралт тохируулах, баланслагч хаалт төлөвлөх; ✓ Халаалтын систем, тоноглолыг орчин үеийн дэвшилтэт технологитой, гидравлик болон шугамын алдагдал багатай эрчим хүчний хэмнэлттэй материал тоноглолуудыг сонгох; **Мэдээлэл холбооны сүлжээ, дохиолол :** ✓ Аюулгүй байдлыг хангах зорилгоор камерын систем бүрэн төлөвлөсөн байх. ✓ Мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээнд холбох; ✓ Утасгүй интернэтийн төхөөрөмж төлөвлөх; ✓ Зарлан мэдээлэх, галын дохиолол, дотоод сүлжээ, суурин телефон утасны сүлжээ, гадна дотор камерын системийг стандартын дагуу төлөвлөх; ✓ Барилгын аюулгүй байдлыг хангаж галын гидрант, утаа мэдрэгч *төлөвлөж өгөх. БНбД 21-04-05 Барилга байгууламжийн гал унтраах* автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэлийг суурилуулж өгөх **Халуун усны барилгад тавигдах үндсэн норм дүрмүүд:** • **Усан хангамж ба ариутгах татуурга:** БНбД 40-01-06 (Барилгын дотоод усан хангамж, ариутгах татуурга), БНбД 40-02-06 (Гадна ус хангамжийн сүлжээ), БНбД 40-05-98 (Усан хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ). • **Халаалт, халуун ус:** БНбД 41-01-11 (Барилгын дотоод халаалт, агааржуулалт, халуун ус). • **Барилга угсралт:** БНбД 31-03-03 (Олон нийтийн барилга байгууламж). • **Ус хангамжийн аюулгүй байдал:** MNS BS 8525-1:2015 (Сөрөг урсгалаас хамгаалах төхөөрөмж)
17.	Талбайн өндөржилтөд тавигдах шаардлага	• Авто замын улаан шугам, өндөржилтийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөлтийн талбайд нэгдсэн өндержилт төлөвлөнө.
18.	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт,	• Хэмжилтийг газар дээр нь хийж, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан төлөвлөлт, зураг төслийг гаргах, • Шугамын трассын дагуу инженер геологийн дүгнэлт гаргасан байх,

	далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	• Инженерийн шугам сүлжээний тодруулга авч трассыг сонгох, трасс дагуу үерийн усны хамгаалах шуудуу, далангийн ажлыг төлөвлөж, хөрсний нуралтаас хамгаалах бэхэлгээ, далан, суваг, гарц, зам, талбай барьж байгуулах урьдчилсан арга хэмжээг тусгана. • Эдэлбэр газарт байр зүйн зураглалын тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр Загвар зургийг боловсруулна. • Барилгажих талбайд инженерийн шугам сүлжээ таарсан тохиолдолд холбогдох газартай зөвшилцөж, шилжүүлэх боломжтой эсэхийг тодруулсны дараа Загвар зургийг боловсруулна. • Газрын доорх болон гадаргуугийн ус ашиглах, зайлуулах арга хэмжээг орчны төлөв байдалтай уялдуулан талбайн хэмжээнд иж бүрэн шийднэ. • Газрын ±0.00 төвшнөөс доош төлөвлөж буй байгууламжид гадаргын ус орохоос сэргийлж, ус зайлуулах систем төлөвлөнө.
19.	Төлөвлөлтийн онцгой нөхцөл	• Барилга угсралтын явцад болон ашиглалтын үед бууръ хөрснөөс ус нэвчихээс хамгаалах, цэвдгээс барилга байгууламжид үзүүлэх сөрөг нөлөөг бууруулж, барилгын суурийн бат бөх чанар, насжилтыг уртасгах дэвшилтэт технологи, хийц төлөвлөх • Барилгын бүтээцийг цэвдэгтэй, суумтгай хөрсний сөрөг нөлөөнөөс хамгаалж, суултанд тэсвэртэй төлөвлөх • Газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг судалж, газар хөдлөлтийн бүс нутагт барилга, байгууламж төлөвлөх барилгын норм ба дүрэм БНбД 22-01-21, Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм" БНбД 22-04-16, Барилгын бууръ суурийн норм ба дүрэм (БНбД 50-01-16) – г тус тус баримтлан төлөвлөх; • Инженерийн шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. • Инженерийн шугам сүлжээний /ус хангамж ба ариутгах татуурга/ хамгаалалтын зурвас тогтоон төлөвлөлт хийх, • Халуун усны барилга болон уурын зуух, усан сангийн байгууламжид гадаах болон дотор үйл ажиллагааг хяналтын системд холбон камержуулах, • Үер ус, аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх байдлыг хангасан байх, • Барилгын дээврийг ашиглалттай байх оновчтой шийдлийг тусгах; • Дэвшилтэт техник, технологи, цахилгаан, дулаан, уур, усны эх үүсвэрийг үр ашигтай төлөвлөх /эрчим хүчний хэмнэлттэй/; • Барилгын эрчим хүчний хэрэглээний 30%-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах технологийн шийдэлтэй байх /боломжтой бол/; • Галын аюулаас хамгаалах шаардлагыг мөрдөх, гал илрүүлэх болон унтраах зориулалттай автомат систем төлөвлөх, • Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба саадгүй, түргэн аврагдах гарцыг төлөвлөх • Төлөвлөлтийн шаардлагаар гарсан онцгой нөмөлт өөрчлөлтүүдийг тусгах.
20.	Галын аюулгүй байдлын нөхцөл	• "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл" БН6Д21-04-05, • Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНбД 21-02-02/, • Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал /БНбД 21-01-02/ болон холбогдох норм дүрмийн шаардлага хангасан орц гарцтай байхаар төлөвлөлтийг хийнэ.
21.	Газар хөдлөлийн эрчим	• Газар хөдлөлийн 7,8,9 балл тус бүрд төлөвлөх.
22.	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	• Зураг төсөлд тусгагдсан ажилбар тус бүрээр ажлын төсөв боловсруулах ба нэгдсэн төсвийн нэгтгэл хүснэгтээр нийт хөрөнгө оруулалтын ажлыг нэгтгэж төсөвлөнө. Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81- 95-12/2020 дүрмийн дагуу, шинэчлэгдсэн ESTIMATOR-PRO программ ба

		түүнтэй ижил, цалинг дундаж зэргээр тооцдог, зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно. /Шинэчилсэн программаар төсвийг бодсон байх шаардлагатай/
23.	Нэмэлт	• Ажил гүйцэтгэхэд ашиглах материалыг Захиалагч талд урьдчилан мэдэгдэж, зөвшилцөх боломжтой. • Асууж тодруулах, зөвлөгөө авах шаардлага гарвал Захирагчийн ажлын албаны холбогдох мэргэжилтэн болон "Шим-Ус" ХХК-ийн ИТА-д хандах боломжтой.
24.	Зөвшилцөх байгууллага	• Ховд аймгийн ЗДТГ, • Онцгой байдлын газар • ГХБХБГазар, Аймгийн ерөнхий архитектор <u>Хангагч байгууллагууд :</u> • Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК, • Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК <u>Ашиглагч байгууллага :</u> • "Шим-Ус" ХХК ► Уулзаж, санал авах, зөвшилцөх, техникийн нөхцөл авах ► Нэгдсэн уулзалт зохион байгуулж, санал авах, зөвшилцөх ►Төлөвлөгөөний баримт бичиг, магадлалын нэгтгэсэн дүгнэлт гаргуулах.

ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(Дугаар: ХОАЖСЗДТГ/20260203006 Төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Захиалагч	Зориулалт
Ховд аймаг, Ховд хот, 9-р баг, Рашаант баг, Сангийн - 10 гудамж, 1001 тоот, Шуудангийн бүсчлэл – 84147 Хуучин Шим-Усны халуун ус	Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Ховд хотын Захирагчийн ажлын алба	Наран, Рашаант багийн халуун усны барилга, 2 давхар

ТОДОРХОЙЛОЛТ

A	*Төлөвлөж буй байршил*
B	*Одоо байгаа барилга*
C	*Одоо байгаа худаг*
D	*Авто зам, талбай*

ТӨСЛИЙН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ		
1.	Барилгажих талбай ($м^2$)	196 $м^2$ + гадна тохижилт ($м^2$) + автозогсоол ($м^2$) + явган зам талбай ($м^2$) + орц,гарц ($м^2$)
2.	Төслийн талбай ($м^2$)	1122 $м^2$

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЛЦОЛ

Цэгийн дугаар	X	Y	Тал = урт (м)
1	48.01160879143515	91.64434028601194	1 – 2 = 23.5 урт (м)
2	48.01158194241003	91.64466295959056	2 – 3 = 47.1 урт (м)
3	48.01117083551259	91.64459480465105	3 – 4 = 24.7 урт (м)
4	48.011187638729524	91.6442816439555	4 – 5 = 47.8 урт (м)

ХОВД ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

Хаяг: Монгол Улс, Ховд хот, Алагтолгой баг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, 2 давхарт, 210 тоот

Facebook : "ХОВД ЗАХИРАГЧ АЖЛЫН АЛБА"

ЗАГВАР ЗУРГИЙН БҮРДЛИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Д/Д	Альбомын бүрдэл	ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БАТЛАХ ЭСЭХ	ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
1.	НҮҮР ХУУДАС	Ерөнхий архитектор батална.	- Батлагдсан маягтын дагуу боловсруулах. - Албан тушаал, овог, нэр зөв бичих - Байгаль орчин аялал жуулчлалын яамтай зөвшилцөхөөс бусад тохиолдолд гарын үсэг зурах хүснэгтээс БОАЖЯ -г хасах
2.	Батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгавар	Зөвшилцсөн нэгжийн тэмдэг	- Батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгаврыг зургийн бүрдэлд оруулах. - Архитектур төлөвлөлтийн даалгавар уншигдах тод байх. - Зураг төсөл зохиогчийн тусгай зөвшөөрөл болон мэргэшсэн, зөвлөх архитекторын гэрчилгээний хуулбар
3.	Орчны тойм	Зөвшилцсөн нэгжийн тэмдэг	- М1:2000-5000 масштабтай, төлөвлөж буй объектоос 100-200 метрийн хүрээнд хамаарсан байх. - Хөгжлийн өрөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, одоогийн барилгажилт, гудамж замын сүлжээ бүхий зураглал байх. - Орчны тоймын зураглалыг Архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт схем зургийг ашиглан гүйцэтгэсэн байх. - Бусад зураглалаас эрөхгүй байх - Хүчин чадлын хүснэгтийг барилгын зориулаптын дагуу арын хүснэгтээс сонгох
4.	Төлөвлөлтийн санаа	Зөвшилцсөн нэгжийн тэмдэг	- Архитектур төлөвлөлтийн анхны ерөнхий санаа, архитектурын хэв маяг, онцлог, утга агуулга, бэлгэдлийг гар эскиз болон компьютер график ашиглан тусгах. - Зохиогчийн эрхийг баталгаажуулсан тайлбар, нэмэлт мэдээлэл тусгах.
5.	ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	Ерөнхий архитектор батална.	- Батлагдсан маягтын дагуу боловсруулах. - Ерөнхий төлөвлөгөөний зураглалыг зөвхөн М1:500, М1:1000 масштабтай боловсруулах. - Зөвхөн А3 форматаар хэвлэх. - Зүг чиг, шугаман масштабын тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу тэмдэглэх. - Эдэлбэр газар, төлөвлөлтийн хязгаарт одоо байгаа барилга, байгууламжийн ББХ, ДТХ-ны үзүүлэлтэд оруулан тооцох. - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн шаардлага хангуулах. - Одоо байгаа барилга байгууламжийн зай хэмжээг тусгах - AutoCad программ хангамж ашиглан боловсруулсан тоон файлыг барилга, авто зам, явган зам, ногоон байгууламжийг polygon байдалд бэлтгэн хүлээлгэн өгөх.
6.	Хөдөлгөөний схем	Зөвшилцсөн нэгжийн тэмдэг	- Гудамж замын болон тухайн барилга байгууламжруу зүглэх явган зорчигч, унадаг дугуйн зам, авто тээврийн хөдөлгөөний урсгалыг үзүүлэх, хөдөлгөөний урсгал тасралтгүй байх. - Галын болон түргэн тусламжийн машин чөлөөтэй нэвтрэхээр төлөвлөх. - Хөдөлгөөний схем нь 4 төрлийн өнгөөс бүрдсэн байх - Хөдөлгөөнөөс бусад зураглал нь хар, саарал өнгөтэй байх
7.	Тохижилт	Зөвшилцсөн нэгжийн тэмдэг	- Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зүлэгжүүлэлт, моджуулах,амрах, тохижуулах, тоглох, спорт талбайн зай хэмжээ,тоог тусгах

ЖИЧ : Загвар зургийн ерөнхий шаардлага хангаагүй тохиолдолд зөвшилцөхгүй.

ЗАГВАР , ЖИШЭЭ ЗУРАГ

/Барилгын ерөнхий харагдах байдал/

Барилгын нүүрэн талын харагдах байдал

Барилгын хажуу талын харагдах байдал

БОЛОВСРУУЛСАН :

ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..... / Д.АРИУНБОЛД /

ХЯНАСАН :

ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГА ..... / Я.МӨНХ-ОРГИЛ /

ПКОА0350

2026.02.23-ны өдөр.